



МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

1994 оны
сарын 04 өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

Залуучууд, биеийн тамир, спор-
тын байгууллагын тухай

I. Монгол улсын Засгийн газрын 1994 оны 50 дугаар тогтоо-
лыг үндэслэн 1994 оны 4 дүгээр сарын 8-наас эхлэн нийслэлийн
болон дүүргүүдийн Засаг даргын дэргэдэх залуучууд, спортын хо-
роогыг татан буулгаж, нийслэлийн Засаг даргын дэргэд Биеийн та-
мир спортын хороог, Баянгол, Баянзүрх, Хан-Уул, Сүхбаатар, Чин-
гэлтэй, Сонгинохайрхан, Налайх, Багануур дүүргүүдийн Засаг дар-
гын тамгын газрын дэргэд Биеийн тамир спортын сургалтын төвүү-
дийг, Багахангай, Гачуурт, Туул, Шаргалант дүүргүүдэд "Залуучууд,
биеийн тамир спортын асуудал хариуцсан нэг хүнийг тус тус одоо-
гийн орон тоо, төсөвтөө багтаан ажиллуулсугай.

2. Залуучууд, биеийн тамир спортын төв, орон нутгийн байгуул-
лагын зохион байгуулалтын өөрчлөлттэй холбогдуулан нийслэлийн
Засаг даргын тамгын газрын нийгэм, эдийн засгийн бодлогын хэл-
тэст "Залуучуудын тасаг"-ийг шинээр гурван орон тоотойгоор, дүүр-
гүүдийн Засаг даргын тамгын газруудад залуучуудын асуудал хариуц-
сан тус бүр нэг орон тоог өөрсдийн төсөвт багтаан ажиллуулахыг
зөвшөөрсүгэй.

3. Шинэ зохион байгуулалттай холбогдуулан Хотын биеийн тамир,
спортын хорооны орон тоо, дүрэм, үндсэн чиглэлийг хавсралтаар
баталж, дүүргүүдийн биеийн тамир, спортын сургалтын төвүүдийн
бүтэц, зохион байгуулалтыг шийдвэрлэж, төсөв зарцыг нь батлаж
өгөхийг Биеийн тамир спортын хороо /н.Соцномзундуй/, Санхүүгийн
газар /н.Тонгор/, дүүргүүдийн Засаг дарга нарт тус тус
даалгасугай.

4.Энэ захирамж гарсантай холбогдуулан Улаанбаатар хотын АДХ-нн гүйцэтгэх захиргааны 1991 оны 235, 1992 оны 17 дугаар тогтоолууд, 1993 оны 107 дугаар тогтоолын I дүгээр заалт, 1988 оны 308 дугаар тогтоолын 4 дүгээр заалтын "а" хэсэг, 1991 оны 03 дугаар тогтоолын I дүгээр заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ
ДАРГА

Ц.Баасанжав


Ц.БААСАНЖАВ

Засаг захиргааны хэлтэс
Боловсруулсан *Д.В.Иснэгт*
6% М.Ц
НИЙЛСЭН *Д.В.Иснэгт*

108

Нийслэлийн Засаг даргын 1994
оны 62 дугаар тоот захирамжийн
I хавсралт

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
БҮЕИЙН ТАМИР СПОРТЫН ХОРООН БҮ-
ТЭЦ, ЭСХИОН БАЙГУУЛАЛТ



100
Нийслэлийн Засаг даргын 1994
онд 4-5/ тоот захирамжийн
II хавсралт

НИЙСЛЭЛИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН
ХОРООНЫ ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Нийслэлийн биеийн тамир спортын хороо нь нийслэл хотод спортын талаар явуулах бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх төрийн захиргааны байгууллага юм.

2. Хорооны үндсэн зорилт нь: Нийслэлд спортыг эрчимтэй хөгжүүлж нэгдсэн удирдлагаар хангах, биеийн тамир спортын материаллаг баазыг бэхжүүлж боловсон хүчний хангамжийг сайжруулахад оршино.

3. Тус хороо нь нийслэлийн Засаг даргын Тамгын газрын удирдлагын дор үйл ажиллагаагаа явуулна.

4. Биеийн тамир спортын байгууллагын тогтолцоо нь биеийн тамир спортын хороо, түүний шууд харьяа газар, нийслэлийн дүүргийн биеийн тамир спортын сургалтын төв, тэдгээрт захирагдах нэгжээс бүрдэнэ.

5. Хороо нь үйл ажиллагаандаа Монгол улсын хууль тогтоомж, Улаанбаатар хотын Засаг даргын захирамж, энэ дүрмийг удирдлага болгоно. Хороо нь эрх хэмжээнийхээ асууцлаар Монгол улсын хууль тогтоомжинд нийцүүлэн тушаал гаргаж биелэлтийг хангуулна.

Хорооноос гаргасан биеийн тамир спортын холбогдолтой нийтлэг шийдвэрийг холбогдох газар, дүүргүүдийн Засаг даргын Тамгын газар, улс, хоршоолол, олон нийтийн болон хувийн үйлдвэр, байгууллага, иргэн бүр биелүүлэх үүрэгтэй.

6. Хороо нь боловсон хүчин, бусад ажлын үзүүлэлтээр Улаанбаатар хотын Засаг даргын Тамгын газарт харьяалагдана.

7. Хороог нийслэлийн Засаг даргын захирамжаар батлагдсан дарга удирдах бөгөөд хорооны ажлаа нийслэлийн Засаг даргын өмнө бүрэн хариуцна.

8. Хороо нь үүрэг зорилтоо хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх байхын тулд хорооны гишүүдтэй байна.

Гишүүдийг хорооны даргын тушаалаар батлана. Хорооны дарга нь Монгол улсын хууль тогтоомжинд нийцүүлэн эрх хэмжээнийхээ

асуудлаар санал боловсруулж, нийслэлийн Засаг даргын зөвлөл, Тамгын газарт оруулах ба гарсан шийдвэрийн биелэлтийг хангана.

9.Хороо тогтоосон журмаар хийсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

Хоёр.Үүрэг, эрх

I.Хороо дор дурдсан үүрэг гүйцэтгэнэ.

а/Үндэсний өв уламжлалд тулгуурлан нийслэлийн хүн амын дунд ардын тоглоом, наадам, спортын үндэсний болон дэлхий нийтийн төрлийг хөгжүүлэх төрийн бодлогыг холбогдох газар, олон нийтийн төв байгууллагуудтай хамтран боловсруулж хэрэгжүүлэн биелэлтэд нь хяналт тавих.

б/Нийслэл хот, дүүргийн хэмжээнд зохиогдох уралдаан тэмцээн, спорт сургалтын ажлыг арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах;

в/Талаад орнуудын нийслэлийн биеийн тамирын байгууллагатай спортын талаар хамтран ажиллах;

г/Харьяа байгууллагын үйл ажиллагаанд захиргааны болон санхүүгийн хяналт тавих;

д/Хоросны ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

е/Биеийн тамир спортын материалыг баазыг бэхжүүлэх, тоног төхөөрөмж, хувцас хэрэгслэлийн хангамжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг дэмжих;

ж/Нийслэл хотод биеийн тамир спортын арга хэмжээг нэгдсэн төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, түүнийг биелэлтэд хяналт тавина.

2.Хороо дор дурдсан эрх өдлөнэ.

а/Харьяа байгууллагыг байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг зохих журмын дагуу нийслэлийн Засаг даргын Тамгын газарт оруулж шийдвэрлүүлэх, тэдгээрийн удирдах албан тушаалтныг томилоход санал өгөх;

б/Нийслэлийн Засаг даргын Санхүүгийн газраас баталсан сарын цалингийн санд багтаан аппаратынхаа бүтэц, орон тоог батлуулах;

в/Хүн амын дунд зохиох спортын сургалтын хөтөлбөр, нэгдсэн ангилал, бусад нормативыг холбогдох байгууллагуудтай хамтран боловсруулж саналдаа өгөх;

г/Эрхэлсэн ажлын холбогдолтой мөнээ материалыг холбогдох газар, пүүргүүдийн Засаг даргын Тамгын газар, бөхийн тамир спортын сургалтын төв бусад байгууллагаас гаргуулан авах;

д/Хорооны эрх хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогцуулан дэргэдээ орон тооны бус комисс, зөвлөлийг байгуулж ажиллах, тодорхой асуудал боловсруулахад зохих мэргэжлийн хүмүүсийг холбогдох байгууллагатай нь зөвшөөрөлцсөнийг үндсэн дээр урьж оролцуулах;

е/Спортын арга хэмжээний төсвийг батлуулж хуваарилан олгох, ашиглалт зарцуулалтад хяналт тавих;

ж/Эрхэлсэн асуудлаар талаар орнуудын нийслэл хотуудтай хамтран ажиллах гэрээ хэлэлцээрийг зохих журмын дагуу баталж хэрэгжүүлэх;

з/Нийслэл хотод спортыг бэхжүүлэх үйлсэд тодорхой хувь нэмэр оруулсан, спортын тарамгай амжилт гаргасан хүмүүсийг Монгол улсын алдар цол, төрийн цээл болон Засгийн газрын шагналаар шагнуулах саналыг зохих журмын дагуу эрх бүхий байгууллагад оруулах, тус хорооны шагналаар шагнах.

Нийслэлийн засаг даргын 1994
оны 4-54 тоот захирамжийн III
хавсгал

НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН
ХОРООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН
ЧИГЛЭЛ

Улс төрийн шинэ тогтолцооны нөхцөлд төрийн бодлого, үүрэг лавхар гүйцэтгэж байсан олон нийтийн байгууллагуудын үзэл баримтлал, үйл ажиллагаа шинэчлэгдэн өөрчлөгдөж байгаагаар холбогдон спортын талаархи төрийн бодлогыг боловсруулан хэрэгжүүлэх нийслэлийн биеийн тамир спортын хороо үйл ажиллагааныхаа үндсэн чиглэлийг дор дурдсанаар тодорхойлж байна.

Нэг. Спортын талаархи бодлого

Ард түмний уламжлалт ёс заншил, соёл иргэншил, улс орны эдийн засгийн онцлогийг үндэс болгон орчин үеийн шинжлэх ухааны ололтод тулгуурласан спортын хөгжлийн шинэ тогтолцоог бий болго зорилтыг хэрэгжүүлнэ.

а/Спортын материаллаг бааз, боловсон хүчин, спортын шинжлэх ухааны дээшиллийн бодлого, санхүүгийн оновчтой бодлогыг явуулж спортын эрчимтэй хөгжлийн хэтийн чиг бодлогыг хэрэгжүүлэх, эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэхийн тулд:

-төсвийн зарцуулалтыг оновчтой болгох, спортоор хичээллэгчдийн тоогуны болон бие бялдарын эрэлт хэрэгцээ, спортын орчин үеийн сургалт дасгалжуулалтын шаардлагыг хангахуйч материаллаг ахуй нөхцөлийг бий болгоход анхаарлаа төвлөрүүлнэ.

-улс хоршоолол, үйлдвэр эв ахуйн газар, байгууллага, хувь хүн спортын жижиг дунд, хувийн үйлдвэрийг хөгжүүлэх, спортын салбарт техник, технологийн шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлэх.

-Спортын хэрэглэл материалаар үнэ төлбөртэй үйлчлэх цэг салбарыг олшруулан хүчин чадлыг нь ихэсгэж үйлчилгээний тав тухтай нөхцөл бүрдүүлэх, спортын материаллаг баазын ашиглалтыг үндэсээр нь сайжруулж шинээр барих спортын ордон, заалын суудлын тоог нормативт хэмжээнд хүргэх, спортын арга хэмжээний шагнал үр нөлөөг дээшлүүлж зохион байгуулснаар энэ чиглэл хэрэгжи

Үүнд:

-Улаанбаатар хотод 5000 хүний суудалтай бөхийн ордон спорт аялалын болон цанын бааз байгуулж, төв цэнтэдэх хүрээлэнгийн өргөтгөл хийх.

-Өдөрт 6000 хүн хичээллэх спортын цогцолборыг ашиглалтанд оруулах.

-Улс, хоршоолол, олон нийтийн байгууллагын хөрөнгө хүчээр спортын хялбар хийц бүхий спортын танхим талбай байгуулах санаачлагыг өрнүүдснээр 1000 хүнд ногдох спортын битүү барилга байгууламж ашигтай талбайг өргөтгөх.

-Тамирчид, багш дасгалжуулагчдаас оюуны болон бие бялдрын чадавхаа бүрэн дайчлан чөлөөтэй өрсөлдөх нөхцөл боломжийг бүрдүүлэх.

-Спортын салбарын шинжлэх ухаан, онолын сэтгэлгээг эрчимтэй хөгжүүлэх, түүний практик үр өгөөжийг нэмэгдүүлэх судалгаа сургалтын ажлыг явуулах зэрэг зорилтуудыг төвж ажиллана.

б/Спортыг эрчимтэй хөгжлийг хангах бодлого

-Спортын хөгжлийн нийгэм эдийн засгийн баталгаа иргэдээс бие бялдараа чийрэгжүүлэх талаар хүлээх үүрэг тамирчид, багш, дасгалжуулагч, спорт сонирхогчдын эрх ашгийг хамгаалахтай холбогдсон асуудлыг хуульчлан зохицуулсан биеийн тамирын спортын хуулийг бодовсруулахад идэвхтэй оролцох.

-Үр өгөөж багатай уралдаан тэмцээн явуулж буй өнөөгийн зохион байгуулалт, арга хэлбэрийг өөрчилж материаллаг баазын хангамж, уламжлалт байдал, шинжлэх ухаанд тулгуурласан спортын сургалт, уралдаан тэмцээний шинэ тогтолцоог бий болгох.

-Спортын байгууллагуудын үйл ажиллагааг дээрээс хэт загварчлан заадаг хуучин зарчмыг өөрчлөж тухайн байгууллага, хамт олны бие даасан байдал, үүсгэл санаачлагыг дэмжин тэтгэх уян хатан бодлого баримтлах.

-Спортын төрлүүдийг хөгжүүлэх, сургалт дасгалжуулалт, уралдаан тэмцээн явуулах, тамирчдын амжилтыг ахиулах зэрэг асуудлыг

3.

спортын холбоод, нэгдсэн ба төрөлжсөн клубуудад хариуцуулах тэднийг зохион байгуулалт, эдийн засгийн талаар бие дааж ажиллахад нь тусалж дэмжих.

-Спортын сурталт, заах арга, сурталчилгааны сэдэвтэй зөвлөмж, гарын авлага, плакат, зарлал, нүрс бичлэг, радио телевизийн нэр төрөл /нэвтрүүлгийн / тоо хэмжээг нэмэгдүүлж спортын амьдралын үйл явцыг олон түмэнд шуурхай мэдээлэх арга хэмжээг зохион байгуулах.

-Гадаад орнуудын нийслэлийн спортын байгууллагуудтай харилцаагаа улам өргөжүүлж дэмжлэг туслахаа авах зэрэг асуудлуудыг хөгжүүлэхэд үйл ажиллагааныхаа үндсэн чиглэл болгон ажиллана.